



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/306

Мандалговь

Хүүхдийн спортын наадмын бэлтгэл ажлыг
хангах ажлын хэсэг томилох тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.1.2, Бага дунд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйл 18.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 354 дугаар тогтоол, 2018 оны 183 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/777 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монголын хүүхдийн спортын VI наадмын бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ж.Мөнхчулуун (Аймгийн Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: М.Наранбадрах (Биеийн тамир, спортын газрын дарга)

Гишүүд: А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Ц.Ганзориг (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)

Ц.Бумангэрэл (Боловсрол, соёл, урлагийн газрын дарга)

Хоёр. Монголын хүүхдийн спортын VI наадамд оролцох баг тамирчдын бэлтгэлийг бүрэн хангаж, оролцуулахыг ажлын хэсгийн дарга (Ж.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190391